Тайлант хугацаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй. Цаашид дотоод хяналт шалгалтыг тогтмолжуулж, үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2016 онд шинэчлэн боловсруулагдсан 8 хэсэг, 26 дэд хэсэгтэй байна. Төв аймгийн СТСХ-с нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нэгдсэн журмаар боловсруулж өгөх чиглэл өгсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинээр гарсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад бүрэн нийцэхгүй болсон.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 572.3 сая төгрөгөөр буюу 21,1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | |
| Авлага | 78,635.0 | 442,425.7 | 363,790.7 |
| Бараа материал | 82,760.4 | 83,763.7 | 1,003.3 |
| Үндсэн хөрөнгө | 2,551,476.5 | 2,758,956.2 | 207,479.7 |
| **Нийт хөрөнгө** | **2,712,871.9** | **3,285,145.7** | **572,273.8** |
| Өр төлбөр | | 1,453.5 | 1,453.5 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,712,871.9 | 3,283,692.2 | 570,820.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,712,871.9** | **3,285,145.7** | **572,273.8** |

Дээрх хүснэгтээс харахад авлага дансны үлдэгдэл 442,425.7 мянган төгрөг болж өмнөх оноос 363,790.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлууд бүрэн хийгдэж дуусаагүйгээс 438,245.7 мянган төгрөгийн ажлыг авлагаар бүртгэж тайлагнасан. Мөн өвс тэжээлийн фондод хивэг авахаар жилийн эцэст мөнгөө шилжүүлсэн боловч татаж авч амжаагүй 4,180.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн. Мөн оны эхний үлдэгдлээс 50,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй зэргээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэлд нөлөө үзүүлэхүйц өөрчлөлт гаргаагүй өмнөх оноос 1,003.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Бараа материалын дансанд тайлант хугацаанд 69,685.3 мянган төгрөгийн орлогын, 68,682.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 2,758,956.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 207,479.7 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь Орон нутгийн шилжих үлдэгдлээс хийгдсэн 239,575.7 мянган төгрөгийн ажлуудыг болон ОНХС болон бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй бэлтгэсэн 209,483.9 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж тайлагнасан. Төв аймгийн ИТХ-ын 14 дүгээр хуралдааны 08 дугаар тогтоолын дагуу 4 тээврийн хэрэгсэл худалдахаар шийдвэрлэгдсэнээс 3 тээврийн хэрэгсэл худалдагдсан тул 43,300.0 мянган төгрөгөөр данснаас хассан. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн байгууллагуудад хийгдсэн 58,446.9 мянган төгрөгийн ажлыг шилжүүлж тайлагнасан болон тайлант онд бүртгэсэн хөрөнгийн элэгдлийн зардал зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансанд шатахууны зардал хүрэхгүйгээс 1,453.5 мянган төгрөгийн өрийг шинээр үүсгэсэн байна.

Засгийн газрын сан нь тайлант оны үр дүн 570,820.3 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баян сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 436,483.3 мянган төгрөг, нийт зарлагыг 436,483.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 308,614.8 мянган төгрөгөөр өсгөж 745,098.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсөлд тусгагдаагүй байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд 118,110.4 мянган төгрөг, орон нутгийн шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 108,145.6 мянган төгрөг нэмж баталснаас шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 983,312.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,728,410.5 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Энэ нь тайлант онд Засгийн газраас цалин хөлсийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 74,895.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг 888,485.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 996,630.7 мянган төгрөг болгон тодотгож, орон нутгийн хөрөнгийн санхүүжилтээр хийгдэх ажлын жагсаалтад өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,728,410.5 мянган төгрөгийг сумын татварын орлогоор бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос урсгал зардалд 716,779.8 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 1,011,630.7 мянган төгрөг, нийт 1,728,410.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,152,806.2 мянган төгрөг буюу 66,7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 46,111.9 мянган төгрөгөөр, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 4,541.2 мянган төгрөгөөр, баг хорооны үйл ажиллагааны зардлыг 143.3 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 416,676.0 мянган төгрөгөөр, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажил үйлчилгээний зардлыг 108,110.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Тайлант оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 575,604.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70106-80101 үндсэн үйл ажиллагааны зардал | 428,961.0 | 382,849.1 | 46,111.9 | 89,3 |
| 2 | 70106-80103 гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ | 79,405.0 | 74,863.8 | 4,541.2 | 94,3 |
| 3 | 70106-80106 баг хорооны үйл ажиллагааны зардал | 61,012.3 | 60,869.0 | 143.3 | 99,8 |
| 4 | 70106-80802 ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 16,791.1 | 16,781.4 | 9.7 | 99,9 |
| 5 | 70106-80918 бусад | 1,011,630.7 | 594,954.6 | 416,676.0 | 58,8 |
| 6 | 70106-81102 орон нутгийн нөөц хөрөнгө | 5,000.0 | 4,993.6 | 6.4 | 99,9 |
| 7 | 70106-82801 улсын их баяр наадам | 5,000.0 | 5,000.0 | 0 | 100 |
| 8 | 71411-81701 байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 108,110.4 | 0 | 108,110.4 | 0 |
| 9 | 71411-82212 хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ | 12,500.0 | 12,494.6 | 5.4 | 99,9 |
| | | 1,728,410.5 | 1,152,806.2 | 575,604.3 | 66,7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант онд урьд оны үлдэгдэл 13,786.6 мянган төгрөг, Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой УИХ-н гишүүн Н.Энхболдоос шатахууны дэмжлэг 1,000.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын шатахууны зардал, урамшуулалд 489.4 мянган  төгрөг, Орон нутгийн нэмэгдэлд 31,275.2 мянган төгрөг, эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын зардалд 119,600.0 мянган төгрөг, Цахим тендерийн хураамж 315.0 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэ 10,422.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын ажлын барьцаа мөнгө 5,438.4 мянган төгрөг,  орон сууцны түрээс 132.0 мянган төгрөг буюу нийт 213,567.0 мянган төгрөгийн орлого төвлөрснөөс 65,048.3 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 148,518.7 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 2023.01.01-2023.12.31 | Төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ. | Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 80.7 % , сумын 2023 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 80.3 %, төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 91%, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр 91 %-тай хэрэгжсэн | 1,607,800.1 | 1,140,311.6 |
| 2 | 71411 хүрээлэн буй орчны бодлого, удирдлага | 2023.01.01-2023.12.31 | Хог хаягдлын хураамжийн төлөвлөгөөг 100% хангаж биелүүлж, хог хаягдлыг тогтмол цэвэрлэн хур хог хаягдал үүсгэлгүй ажиллана. | 2023  онд иргэн, ААНБ-с нийт 10,846.3 мянган төгрөгийн хог хаягдлын хураамжийн орлого төвлөрүүлсэн. | 120,610.4 | 12,494.6 |
| | | | | | 1728410,5 | 1152806,2 |

Тайлант хугацаанд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар ажил хийгдээгүй тул гүйцэтгэл гараагүй. Иргэд хог хаягдлын хураамжаа бүрэн төлөхгүй байгаагаас шалтгаалан хог хаягдал цэвэрлэх, ачих асуудал хүндрэл гардаг байна.

***3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл***

Төв аймгийн Баян сумын ЗДТГ нь 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу бичиг хэргийн материал, тээвэр шатахуун, урсгал засварын зардал, бараа материал, цэвэрлэгээний материал, шуудан холбооны зардалд, хог хаягдлын зардалд, бараа үйлчилгээний бусад зардлуудыг харилцагч байгууллагуудтай худалдан авах гэрээг байгуулан шууд худалдан авалт хийсэн байна.

Худалдан авах бараа ажил үйлчилгээ цахим дэлгүүрт байршаагүй, үнэ өндөр зэргээс шалтгаалан цахим худалдан авалт хийгээгүй,

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт шинжээч Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүү үр дүнгийн тайлангийн 1,585,921.2 мянган төгрөгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг үзүүлэлтээр Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүү үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,585,921.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 23,788.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 17,841.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд байгаль орныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжээгүйгээс хэмнэгдсэн 575,604.0 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баян сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудсанд байршуулах 159 мэдээлэл байршуулахаас 155 мэдээлэл оруулж, 6 мэдээллийг хугацаа хоцроож илгээсэн төлөвтэй хэрэгжилт 99,5 хувьтай байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баян сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг ЗДТГ-ын 2023 оны 9 дугаар сарын 21-ны өдөр 03/16 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Акт | 1 | 286.9 | 1 | 286.9 | 100 |
| Албан шаардлага | 1 | 7,806.0 | 1 | 7,806.0 | 100 |
| Зөвлөмж | 1 | 455,520.2 | 1 | 455,520.2 | 100 |
| **Нийт дүн** | 3 | 463,613.1 | 3 | 463,613.1 | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баян сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар авлагын барагдуулалт, орон нутгийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт гүйцэтгэлд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 127,492.0 мянган төгрөгийн хоёр алдаа[1] илэрснээс аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд аймгийн СТСХ-ээс тулган баталгаажуулахаар ирүүлсэн батлагдсан төлөвлөгөөнөөс 38,947.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Шинэ хөдөө төслийн хүрээнд ХХААХҮГ-аас 2024 онд ирүүлсэн 57,088.6 мянган төгрөгийн 90 морины хүчин чадалтай трактор, 31,456.0 мянган төгрөгийн үрлүүрийг, нийт 88,544.6 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлогыг хүлээн авсан акт материал санхүүд ирээгүйгээс данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "оршин байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар илэрсэн зөрчил[2] -д 9,494.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, 363,790.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

### 5.2 Төлбөрийн акт

Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл, цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай" Б/02 тоот захирамж, Баян сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн "Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл, цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай" Б/05 захирамжийг үндэслэн улс төрийн 5 албан хаагчид 9,494,692 төгрөгийг орон нутгийн нэмэгдэлд олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д "Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“хуулиар зөвшөөрөөгүй бусад” 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**5.2 Албан шаардлага**

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Санхүүгийн тайлангийн авлага өмнөх оны үлдэгдлээс 363,790.7 мянган төгрөгөөр өсөж, 442,425.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж зааснаг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

2023 онд дутуу гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын ажлыг чанартай гүйцэтгүүлж, хөрөнгийг хүлээн авч, авлагын үлдэгдлийг барагдуулах

2. Хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Сумын ИТХ-аас хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг 996,630.7 мянган төгрөгөөр 20 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас нийт 383,428.9 мянган төгрөгийн 5 ажил огт хийгдээгүй, 388,245.7 мянган төгрөгийн 5 ажлыг дутуу гүйцэтгэсэн нь нийт хөрөнгө оруулалтын ажлын 77,4 хувь нь бүрэн хэрэгжээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-д “төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих” гэж зааснаг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих хяналт шалгалтыг сайжруулж, ажлыг хугацаанд нь гүйцэтгүүлж байх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд

*Илрүүлэлт:*

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасны дагуу 5 суудлын автомашинд тус дугаар авахаас 3 машинд авсан ба 1 машин эвдрэлтэй, сумын

Засаг даргын албан тушаалын LEXUS -470 автомашин бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Сумын Засаг даргын албан тушаалын LEXUS -470 автомашинд тод дэвсгэр бүхий улсын дугаар авах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу Төв аймаг дахь Төрийн аудитын газарт батлагдсан төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 25-ны дотор, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Батлагдсан төлөвлөгөөг зөрүүтэй тайлагнасан | 1 | 38,947.4 | | | 1 | 38,947.4 | 1 | 38,947.4 | | |
| Орлогыг орхигдуулсан | 1 | 88,544.6 | 1 | 88,544.6 | | | 1 | 88,544.6 | | |
| | | | | | | | | | | |
| Дүн | 2 | 127,492.0 | 1 | 88,544.6 | 1 | 38,947.4 | 2 | 127,492.0 | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Авлага өмнөх оны үлдэгдлээс 363,790.7 мянган төгрөгөөр өссөн | 1 | 363,790.7 | | | | | 1 | 363,790.7 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 363,790.7 | | | | | 1 | 363,790.7 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 5 хүнд олгосон | 1 | 9,494.7 | 1 | 9,494.7 | | | | |
| Сумын ИТХ-аас батлагдсан ХО-ийн ажлын 77,4 хувь нь бүрэн хэрэгжээгүй байна | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| LEXUS -470 автомашин нь ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | 3 | 9,494.7 | 1 | 9,494.7 | | | 2 | 0 |
| Нийт дүн | 3 | 9,494.7 | 1 | 9,494.7 | | | 2 | 0 |